

## Д.Равжаагийн “Цаасан шувуу” зохиолын нэгэн гар бичмэлд хийсэн баймж утгын задлал

Ю.Мөнх-Амгалан  
Орхон Их Сургууль, Монгол

### Оршил

Д.Равжаагийн “Цаасан шувуу” хэмээх сургаалын зохиолын хэд хэдэн гар бичмэл эх эдүгээ олдож судалгаа шинжилгээний эргэлтэд хэдийнэ ороод байгаа билээ. Тухайлбал, Ц.Дамдинсүрэнгийн гэр музейн монгол номын хөмрөг, Дорноговь аймгийн Сайншанд хот дахь Говийн ноён хутагтын музей, ОХУ-ын Санктпетербург хот дахь Дорно дахины судлалын хүрээлэнгийн гар бичмэлийн фонд зэрэг газар энэхүү сургаалын зохиолын нийтдээ арав гаруй гар бичмэл эх хадгалагдаж байна.

Бид энэ удаа өөрт олон жил хадгалагдаж байгаа, энэхүү сургаалын зохиолын өөр нэгэн гар бичмэлийн тухай товчхон мэдээлж, улмаар энэ зохиолд илэрсэн баймж утгын хэв шинж, илрэх хэлбэр, үүрэг-утга зүйн онцлогийн талаар голлон өгүүлэхийг зорьсон бөгөөд энэхүү илтгэл маань орчин цагийн монгол хэлний баймжийн айн асуудлыг

цуваа цагийн үүднээс сонирхон үзэж байгаа бидний судалгааны ажлын нэгэн үргэлжлэл<sup>1</sup> гэж бас хэлж болно.

### Гар бичмэлийн ерөнхий байдал.

Энэхүү гар бичмэлийн бүтэн гарчиг нь “*čaṣ-un ḡim-yi toduraṡuluṡči čaṡasun šibaṡu kemegči neretü sudur orosibai a*” (Цагийн жамыг тодруулагч цаасан шувуу хэмээгч нэрт судар оршвой) (Цаашид “Цаасан шувуу” гэж хураангуйлан нэрлэнэ) болно. Уг гар бичмэлийн цаасны хэмжээ нь 26,5 x 13 см, зузаан нь 0,5 см. Бор саарал өнгийн хятад муутуу цаасыг хар өнгийн утсаар товхиж үдсэн бөгөөд хар өнгийн бэхээр бийрээр бичсэн байна. Энэхүү гар бичмэл нь нийтдээ 34 тал бөгөөд үүнээс 1r тал нь гарчигтай, 1v тал нь хоосон ар бөгөөд 2r талаас 10v, 11v талаас 12v, 13v талаас 14v, 15v, 16v, 17r тал буюу нийт 27 тал нь 8 мөрөөр; 11r, 13r, 15r, 16r гэсэн 4 тал нь 9 мөрөөр; 17v тал нь 3 мөрөөр тус тус бичигджээ.

Нийтдээ 11 тал дээр үгийн нөхцөл, үг, холбоо үг, өгүүлбэр зэргийн ямар нэгэн оруулбар хийсэн байна. Үүнд 3r тал нь гурван, 6r ба 14r тал нь тус бүр хоёр, үлдсэн 3v, 4r, 4v, 5v, 7r, 8r, 8v, 14v тал нь нэгжгээд оруулбартай ажээ.

---

<sup>1</sup> “Монголын нууц товчоо”-ны cida-, yada- гэдэг үйл үгийн тухай. - The 9<sup>th</sup> International Congress of Mongolists Devoted to the 800<sup>th</sup> Anniversary of the Yeke Mongol Ulus, Organized under the Patronage of N. Enkhbayar, President of Mongolia (8-12 August 2006, Ulaanbaatar). - Илтгэлийн товчлол (Summaries of Congress Papers). p.107; “Монголын нууц товчоо” - ны cida-, yada- гэдэг баймж үйл үгийн тухай. - “Mongolica”. An International Annual of Mongol Studies. Vol. 20 (41). Уб., 2007. 114-127 дахь тал; Дундад үеийн монгол хэлний cida-, yada- гэдэг баймж үйл үгийн тухай (“Субашид”-ын Сономгарагийн орчуулгын жишээгээр). БНСУ-ын Алтай судлалын холбооноос зохион байгуулсан эрдэм шинжилгээний хурал. Сөүл., 2012.11.17. - Илтгэлийн товчлол. 25-39 дэх тал. 2012년도 전국학술대회 일정 일시: 2012. 11. 17. (토) 12:30 ~ 17:40 장소: 서울대학교 신양인문정보관 국제회의실 주제: 알타이민족의 언어와 문화.

Д.Равжаагийн “Цаасан шувуу” зохиолын нэгэн гар бичмэлд хийсэн баймж утгын задлал

Уг гар бичмэлийн 7г талаас 13v талд, г талын 4, v талын 5 дахь мөрөнд мөрийн дундаас ялимгүй дээгүүрх хэсэгт тамхины галын цог унаж түлэгдсэн болов уу гэмээр цоорхой үүссэн байна.

Манай орны их, дээд сургуулийн хэл бичгийн мэргэжлийн хичээлийн сурах бичиг, сургуулийн хэл зүй зэрэг сургалт судалгааны бүтээлийн хүрээнд гол хэрэглэгдэхүүн болгон хэрэглэж байгаа “Цаасан шувуу” зохиолын эх бол 1992 онд Д.Цагааны сэргээн бэлтгэсэн эх<sup>2</sup> болно. Энэ бол эмхэтгэгчийн хэлснээр “Цагийн жамыг тодруулагч цаасан шувуу хэмээгдэх шашдир оршив”, “Цагийн жамыг тодруулагч цаасан шувуу хэмээгдэх шашдир оршив. Эрдэнэ ноён гэгээний нууцын зохиол хэдэн зүйл оршив гэсэн эмхэтгэл”, “Дөрвөн эхт сургаал”, “Төвд үсгээр, монгол хэлээр бичсэн “Цаасан шувуу” сургаалын хэсэг”, “Акад. Ц.Дамдинсүрэн “Монголын уран зохиолын дээж зуун билиг оршив” (438-445 дахь тал) зэргээс нийлүүлэн засамжилсан” буюу харьцуулан сэргээж бэлтгэсэн нэгэн зүйлийн сонгомол эх маягийн бүтээл юм.

Бид энэхүү 1992 оны эхийг өөрийн хадгалж байгаа эхтэй харьцуулахад олон зүйлийн ялгаа зөрөө байгаа бөгөөд энд сонирхуулан зөвхөн зохиолын эхлэл хэсэг болон төгсгөлийн үгийг зэрэгцүүлэн үзэхэд л дараах байдалтай байна. Үүнд:

1992 оны эхийн эхлэл хэсэг:

**“Цагийн жамыг тодруулагч цаасан шувуу” хэмээх сургаал**

*Гурван эрдэнэд итгэнэ.*

Хязгаар газрын нэгэн хүн (төр гэрэлтийн) тавдугаар  
оны барс сарын 18-ны шөнө зүүдэлсэн нь:

---

<sup>2</sup> Д.Равжаа. “Цагийн жамыг тодруулагч цаасан шувуу” хэмээх сургаал. - Д.Равжаа. Яруу найргийн цоморлиг. Эмхтгэж хэвлэлд бэлтгэсэн доц. Д.Цагаан. Редактор доктор Д.Ёндон. Соёмбо хэвлэлийн газар. Уб., 1992. 185-196 дахь тал.

Нэгэн хүн цаасан шувуу нисгэж байна. Тэр цагт нэгэн хүн ирээд нисгэгч хүнээс ийн асуув.

(Д.Цагаан 1992:185).

Бидэнд хадгалагдаж байгаа эхийн эхлэл хэсэг:

[1r]

**čaγ-un ĵim-yi toduraγuluγčii čaγasun šibaγu kemegči neretü sudur orosibai a ♦**

[2r]

- 1      ☞ γurban erdeni-dür itegemüi: kičaγar γačar-un nigen kümün eyer tabuduγar on-u
- 2      baras sarayin arban nayman-u söni ĵegüdelegsen anu. nigen kümün čaγasun
- 3      šibaγu nisgečü bayimui. tere čaγ-tu nigen kümün iriged nisgegči kümün-eče eyin
- 4      asaγubai:

[2r]

- 1      ☞ Гурван эрдэнэд итгэнэ. Хязгаар газрын нэгэн хүн эеэр тавдугаар оны
- 2      барс сарын арван наймны шөнө зүүдэлсэн нь. Нэгэн хүн цаасан
- 3      шувуу нисгэж байна. Тэр цагт нэгэн хүн ирээд нисгэгч хүнээс ийн
- 4      асуув.

1992 оны эхийн төгсгөлийн үг:

Энэ мэт элдэв зүйлийн үзэгдэл

Бүгд шүтэн барилдлага

Үзэгдлийн төдий хоосон хэмээхийн агаарт

Д.Равжаагийн “Цаасан шувуу” зохиолын нэгэн гар бичмэлд хийсэн баймж утгын задлал

Зүүд замхрав хэмээн хэдэн  
Сайн, муу, үнэн, худал үгсийг  
Наадмын төдий бичсэн  
Цагийн жамыг тодруулагч  
Цаасан шувуу хэмээгдэх нэжгээд үе төгсөв.  
Ом сайн амгалан болтугай.  
Олон амьтанд тус болж  
Орчлонгийн далай ширгээд  
Онолын эцэст хүрч  
Огоот арилсан бурхан болох болтугай!  
(Д.Цагаан 1992:196).

Бидэнд хадгалагдаж байгаа эхийн төгсгөлийн үг:

[17r]

3 (.....) ene metü eldeb  
4 jüil-ün üčegdegči bügüde sadun barildulγ-a üčegdel-yin  
5 tedüi qoγusun kemekü-yin aγar-tur jегüde jamqarbai:  
6 kedün sayin maγu ünen qudal üges-i naγadum-un tedüi  
7 biči[g]sen. ene čaγ-un jīm-yi todurγuluγči čaγasun sibaγu  
8 kemegdekü tegüsbei :::❖..

[17v]

1 vačirdar-a baγsi-yin adistid eyer. onul бүкүн-ү ечүс-түр күрчү  
2 orčilang-yin dalai-i širgegečü getülen. ončitu nom-un biy-e olqu  
boltuγai  
3 oṃ uva mā nī baḍ mā huu:

[17r]

3 ..... Энэ мэт элдэв

- 4 зүйлийн үзэгдэгч бүгд садан барилдлага үзэгдлийн  
5 төдий хоосон хэмээхийн агаарт зүүд замхрав.  
6 Хэдэн сайн муу үнэн худал үгсийг наадмын төдий  
7 бичсэн, энэ цагийн жамыг тодруулагч цаасан шувуу  
8 хэмээгдэх төгсөв.

[17v]

- 1 Очирдарь багшийн адисдидаар, онол бүхний эцэст хүрч  
2 орчлонгийн далайг ширгээж гэтлэн, ончид номын бие олох  
болтугай.  
3 Ум ма ни бад ма хум.

### **Гар бичмэл дэх баймж утгын задлал.**

Энэхүү гар бичмэлийн эхэд илэрхийлэгдсэн баймж чанар, баймж утгын хэв шинж, баймж утгын өнгө аясыг энэ удаа товч боловч товчоолон тодорхойлохдоо орчин цагийн монгол хэлний баймжийн айн судлалын үндсэн судалгаан дээрээ тулгуурласан болно.

Бид орчин цагийн монгол хэлний баймжийн айн асуудлыг нэлээд хэдэн жил тусгайлан судалсны үндсэн дээр энэ айн утга зүйн цөмийг бүрдүүлж өгүүлбэр ба бодомжийн харилцан холбоог нөхцөлдүүлэн өгүүлбэрийн логик – хэл зүйн байгууламжид тулгуурлан илрэх шинжийг **баймжийн айн төвийн тогтолцоо** хэмээн тогтоож энэхүү төвийн тогтолцоонд хамаарах баймж утгыг мэдэгдэхүүний талаас **бодит баймж утга**, хэлний талаас **зайлшгүй баймж утга**, хэлэхүйн талаас **бололцоот баймж утга**, мэдэхүүний талаас **үнэн магадлалт баймж утга** гэсэн дэд тогтолцоонд нэгтгэн зангидаж тодорхойлсон бол ерөнхийдөө логик – хэл зүйн байгууламжид тулгуурлан тухайн үнэлэн өгүүлэгч эзэн биеэс бодит байдалд харьцах харьцааг үйл

Д.Равжаагийн “Цаасан шувуу” зохиолын нэгэн гар бичмэлд хийсэн баймж утгын задлал

хөдлөлийн төлөв байдал, өгүүлбэр ба бодомжийн холбоо, өгүүлэгчийн сэтгэлийн хөдөлгөөн, субъектив хандлага, сэтгэлийн байдал, харилцааны зорилго чиглэл, шинж чанар зэргээр нэмэн дэлгэрүүлж илэрхийлсэн, төвийн тогтолцооны агуулга, багтаамжийг ихэвчлэн харилцааны талаас задлан өргөжүүлсэн шинжийг **баймжийн айн захын тогтолцоо** хэмээн ойлгож үүнд хамаарах баймж утгыг мэдэгдэхүүний талаас **бодит баймж утга**, хэлний талаас **үндсэн баймж утга**, хэлэхүйн талаас **нэмэлт баймж утга**, мэдэхүүний талаас **субъектив баймж утга** хэмээсэн дэд тогтолцоонд ялган тодорхойлсон билээ. (Ю.Мөнх-Амгалан 1993; 1998).

Орчин цагийн монгол хэлний баймжийн айн төвийн болон захын тогтолцоонд хамаарах баймж чанар, баймж утгын хэв шинж, илрэх арга хэрэглүүр нь 19-р зууны үеийн уран сайхны эхэд хэрхэн хэлбэржиж байсныг дараах байдлаар товчоолон үзэж болно. Үүнд:

### 1.1. Бодит баймж чанар.

Бодит баймж чанар нь өгүүлэгчийн зүгээс тухайн өгүүлэмжийн агуулга бодит байдалтай хэрхэн тохирч байгааг илэрхийлдэг бөгөөд дотроо тодорхой бодит баймж утга, тодорхой бус бодит баймж утга хэмээн ялгардаг.

Тодорхой бодит баймж утгыг өнгөрсөн цагийн *-лаа<sup>4</sup>, -в, -сан<sup>4</sup>, сан<sup>4</sup>* + юм; одоо цагийн *-ж (-ч) байна, үйл үг + аа<sup>4</sup> + юм; ирээдүй цагийн -на<sup>4</sup>, -х + юм, нэр үг + болно, нэр үг + болох юм* зэрэг нийлэг, задлаг хэлбэрээр илрүүлнэ.

Орчин цагийн монгол хэлэнд бодит баймж чанар илэрхийлэх үндсэн гол хэрэглүүр болох эдгээр задлаг ба нийлэг хэлбэрүүд нь “Цаасан шувуу” зохиолд хэрхэн илэрсэн байдлыг авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

**“Үйл үг + на<sup>4</sup>” задлаг хам бүтэц.**

Монгол хэлний одоо ба ирээдүй цагийн тодорхой бодит баймж утга илэрхийлэх энэхүү задлаг хам бүтэц нь уг сургаалын зохиолын эхэд 109 удаа буюу хамгийн олон удаа хэлбэржиж, хамгийн өндөр давтамжтай хэрэглэгдсэн байна. Жишээлбэл:

[3r]

4 (.....) keriglebesü amuraŷ sadun-ača

5 salaqu-bar X ~~öbümüi~~

*jöblemüi*

(Хэрэглэвэл амраг саднаас салахаар зөвлөнө<sup>3</sup>).

[3v]

7 (.....) ay-a basa üile-yi X ??? metü ülü

*öri*

8 niŷtalamui.

(Аяа бас үйлийг өр мэт үл нягтална).

[6v]

6 (.....) gem ügei-yi gem-tei-dü onumui. gem-tei-i gem ügei-dü

7 ö[m]egerimüi.

(Гэмгүйг гэмтэйд ононо. Гэмтэй гэмгүйд өмөөрнө).

**“Үйл үг + в” задлаг хам бүтэц.**

Энэхүү задлаг хам бүтцэд тохирох 12 өгүүлэмж уул сургаалын зохиолд бүртгэгдсэнээс бүгд “ГЭ- + в” гэсэн хэлбэртэй байна. Жишээлбэл:

---

<sup>3</sup> 1992 оны эхэд байхгүй юм уу түүнээс ялгаатай тийм жишээ өгүүлбэрийг энэхүү илтгэлд голлон сонгож дурдахыг хичээсэн болно.

Д.Равжаагийн “Цаасан шувуу” зохиолын нэгэн гар бичмэлд хийсэн баймж утгын задлал

[2r]

4 (...) ene šibaγu-yi kiküdü kimda buyu kemebesü kimda geb. basa öber keküdü

5 kimda yaγu bui kemebesü maγu üile kimda geb.

(Энэ шувууг хийхэд хямд буюу гэвэл хямд гэв. Бас өөр хийхэд хямд юу буй гэхэд муу үйл хямд гэв).

Энэхүү загварыг дэлгэрүүлэн бүхэл өгүүлэмжийн хүрээнд ажиглавал эл ГЭ- язгуурт үйл үгээр хэлбэржсэн өгүүлэхүүний өмнө тусагдахуун гишүүн өгүүлбэр байх бөгөөд уг гишүүн өгүүлбэрийн өгүүлэхүүний байранд хямд, цөөн, олон, муухай, сайхан, хортой, тустай, худал, үнэн, муу, сайн гэсэн эерэг ба сөрөг сэтгэлийн үнэлэмж илэрхийлсэн тэмдэг нэр, тооны нэр тохиолдсон бол өгүүлэгдэхүүний байранд нь муу үйл, өөрийн биеийг үл өмөөрөгч хүн, сэрэмжгүй муу заяатан, үл мэдэгч, саруул ухаан, өст сэтгэл, сайхан сэтгэл, энэ нас, гурван эрдэнэ, ном үгүй, чин зориг гэсэн жинхэнэ нэр бүхий хам бүтэц оржээ.

Өгүүлбэрийн өгүүлэхүүний байранд тохиолдож, бодит баймж утга илэрхийлдэг нэгэн өвөрмөц баймж үг бол МӨН бөгөөд энэхүү сургаалын зохиолд 11 удаа бүртгэгдэв. Жишээлбэл:

[12r]

5 (.....) öggübesü eḑ mön. sakibasü sangvar mön. küličebesü quyaγ mön.

6 kečeyebesü bod mön. ese martabasü bislayal mön. medebesü bilig mön.

(Өгвөл эд мөн. Сахивал санваар мөн. Хүлцвэл хуяг мөн. Хичээвэл бод мөн. Эс мартвал бясалгал мөн. Мэдвэл билиг мөн).

## 1.2. Зайлшгүй баймж чанар.

Зайлшгүй баймж чанар нь өгүүлэгчийн эрэлт хэрэгцээ, нийгэм ба хамт олны доторх дүрэм журам, хэм хэмжээ, үйл явдлын логик дэс дараа, чиг хандлага, тодорхой нөхцөл байдал, бусдын хүсэл зоригийн нөлөө зэрэг олон хүчин зүйлтэй уялдан илэрдэг.

Энэ баймж чанарыг дотор нь тухайн өгүүлэмжийн агуулгын эерэг ба сөрөг шинжээр нь зайлшгүй ба зайлшгүй бус баймж утга хэмээн ялгадаг. Энэхүү хоёр зүйл баймж утгын эсрэгцлийг илэрхийлж, нэн идэвхтэй хэрэглэгддэг, үлэмж бүтээлч баймж үг бол **хэрэгтэй, хэрэггүй** гэсэн үгс бөгөөд энэ хоёр баймж үг “Цаасан шувуу” сургаалын зохиолд мөн л эсрэгцэн хэлбэржсэнээрээ онцлог юм.

“Хэрэгтэй”, “хэрэггүй” гэдэг баймж үгийг монголын болон монголч эрдэмтэд баймж сул үг, баймж үг, ёсчилсон баймж үг, туслах үг, тэмдэг нэр, номлосон баймж үг, өгүүлбэрийг даган чимэх үг гэх зэргээр ялгаа зөрүүтэй тодорхойлсон байдаг.<sup>4</sup>

Энэ зохиолд *хэрэгтэй, хэрэггүй* гэсэн баймж үгийн эсрэгцлээр хэд хэдэн бадаг холбож бүтээсэн байна. Уг гар бичмэлд “хэрэггүй” гэсэн баймж үг 11 удаа орсон байх бөгөөд харин 1992 оны эхэд байдаг “Өгүүлсэн үгийг үл авагч хүнд сургаал хэрэггүй” (Д.Цагаан 1992:190), “Их суудлыг хүсэж нэрэлхэгч хүнд сургаал хэрэггүй” (Д.Цагаан 1992:190) гэсэн хоёр мөр энд байхгүй байна.

Тэгвэл энэ гар бичмэлд “хэрэгтэй” гэсэн баймж үг 8 удаа орсон бөгөөд 1992 оны эхэд байдаг “Өвгөд эмгэдийг өргөгч хүнд сургаал хэрэгтэй” (Д.Цагаан 1992:191) гэдэг мөр энэ эхэд байхгүй бол 1992 оны эхэд байдаггүй дараах мөр энэ эхэд байна. Үүнд:

---

<sup>4</sup> Энэ баймж үг болон зайлшгүй баймж утгын тухай дараах бүтээлээс дэлгэрүүлэн үзнэ үү. Үүнд: Ю.Мөнхамгалан 1998:101-115.

Д.Равжаагийн “Цаасан шувуу” зохиолын нэгэн гар бичмэлд хийсэн баймж утгын задлал

[10г]

- 1 (.....) olan nököd-tei  
tayariüči
- 2 kümün-dü surayal kereg-tei.

(Олон нөхөдтэй таарагч хүнд сургаал хэрэгтэй).

Эдгээр жишээнээс үзвэл, дурдсан “хэрэгтэй”, “хэрэггүй” хэмээх баймж үг нь аливаа үйл хөдлөлийг гүйцэтгэхэд тодорхой зөвлөмж болсон шинжтэй, эсвэл үүнийг бүхэлд нь үгүйсгэсэн, хориглосон маягийн утга илэрхийлсэн байх бөгөөд үүгээрээ сургаалын зохиолын үндсэн агуулга, хэлбэржилтэд бүрэн дүүрэн, яв цав нийцсэн байна хэмээн үзэж болно.

### **1.3. Бололцоот баймж чанар.**

Бололцоот баймж чанар нь тухайн үйл хөдлөлийг гүйцэтгэх хүч боломж, авьяас чадвар, бие болоод сэтгэцийн шинж чанартай холбогдсон байна. Энэ баймж чанарыг дотор нь боломжийн ба боломжийн бус баймж утга хэмээн ангилах бөгөөд боломжийн баймж утгыг *чад-, дөнгө-, үйл үг + болно, үйл үг + боломжтой, үйл үг + мэднэ, үйл үг + аргатай, үйл үг + -ууштай (-үүштэй), үйл үг + маар (-мээр, -моор, -мөөр)* зэрэг задлаг хам бүтэц, баймж үг, оруулсан үгийн тусламжтайгаар илрүүлж болно.

#### **“Үйл үг чада-“ задлаг хам бүтэц.**

Монгол хэлний бололцоот баймж чанарын үндсэн хоёр хэв маяг болох боломжийн ба боломжийн бус баймж утгыг илэрхийлдэг *чад-* болон *үл чад-* гэсэн эсрэгцэл байдаг бөгөөд үүний “үйл үг (-ж -ч) + үл чад-“ гэсэн загварт тохирох 4 өгүүлэмж энэхүү сургаалын зохиолоос бүртгэгдэв. Жишээлбэл:

[4r]

5 itegegsin sidun-ača aγurlabaču salaču ülü čidamui  
(Итгэсэн саднаас уурлавч салж үл чадна).

[5v]

4 (.....) adqaγ ügei amuraγ  
5 saγuču ülü čidamui  
(Атхаггүй амраг сууж үл чадна).

[15r]

1 süsüg ügei bögesü burqan-yi sitüčü ülü čidamui. burqan-yi sitüjü  
2 ese čidabasu jarliγ-i daγaču ülü čidamui.  
(Сүсэггүй бол бурхныг шүтэж үл чадна. Бурхныг шүтэж эс чадвал зарлигийг дагаж үл чадна).

**“Үйл үг (-ж -ч) + болно” задлаг хам бүтэц.**

“Цаасан шувуу” зохиолын энэ гар бичмэлд дурдсан задлаг хам бүтэц “... болбол сургаж болно” гэсэн хэлбэрээр 6 удаа тохиолдсоноос дараах нэг мөр нь 1992 оны эхэд байхгүй байна. Үүнд:

[10r]

6 (.....) üilen  
7 -eče jayilγulqu bolbasu surγaču ~~bolbasu~~ bolumui.  
(Үйлээс зайлуулах болбол сургаж болно).

Энэхүү задлаг хам бүтцэд тохирох эдгээр 6 хэлбэр нь үндсэндээ тухайн өгүүлэгчийн нийгэм, хамт олон болон бусад орчинд эзлэх байр суурь, нэр хүнд, хүмүүжил боловсрол, бие болоод сэтгэлийн хүч бололцоо зэрэгтэй холбогдсон баймж утга илэрхийлсэн байна.

Д.Равжаагийн “Цаасан шувуу” зохиолын нэгэн гар бичмэлд хийсэн баймж утгын задлал

#### **1.4. Үнэн магадлалт баймж чанар.**

Өгүүлэмжийн агуулга ба өгүүлэгчийн харьцаа мэдэгдэхүүн буюу бодит байдлын талаас тохирч, үүнд өгүүлэгчийн итгэл үнэмшил хүрэлцээтэй байгааг илэрхийлдэг үнэн магадлалт баймж чанар нь тодорхой бодит баймж утга болон үндсэн баймж чанарын батлах утгатай сүлжилдэн давхцаж илэрдэг тул энэ тухай 1.2 ба 2.2-т товч өгүүлсэн болно.

#### **2.1. Бодит баймж чанар.**

Орчин цагийн монгол хэлний баймжийн айн захын тогтолцооны мэдэгдэхүүний талд хамаарах өгүүлэгчийн хүсэх болон үйл хөдлөлийн арга буюу байдлаар илрэх бодит баймж утга нь дурдсан сургаалын зохиолд илрэн хэлбэржээгүй нь сургаалын зохиол хэмээх төрөл зүйлийн агуулга, өвөрмөц онцлогтой холбоотой байж болох юм.

#### **2.2. Үндсэн баймж чанар.**

Монгол хэлний баймжийн айн захын тогтолцоонд хамаарах үндсэн баймж чанар нь өгүүлбэр ба бодомжийн харьцаан дээр тулгуурлан илэрдэг бөгөөд үүнийг дотор нь өгүүлбэр ба бодомжийн харилцан холбооны заагт илрэх талаас нь батлах баймж утга, үгүйсгэх баймж утга хэмээн ангилдаг.

Батлах баймж утга нь аливаа зөв бодомж бүхий өгүүлбэрт түгээмэл илэрдэг зүй тогтолтой бөгөөд баймжийн айн төвийн тогтолцооны мэдэгдэхүүний талд илэрдэг бодит баймж чанар, мэдэхүүний талд холбогдох үнэн магадлалт баймж чанартай тус тус сүлжилдэн давхцаж илэрнэ.

Харин энэхүү батлах баймж утгын урвуу тал болох үгүйсгэх баймж утгыг илэрхийлэхэд *үл, эс, биш, үгүй (-гүй)* зэрэг утган чимэх үг идэвхтэй хэрэглэгдэнэ.

Үгүйсгэх баймж утга илэрхийлэх өгүүлэмжийн загвар дотроос “үл + үйл үг + на<sup>4</sup>” гэсэн загвараар бүтсэн 29 өгүүлэмж энэхүү сургаалын зохиолд илэрсэн байна. Жишээлбэл:

[5v]

3 (.....) ay-a basa qariyu ügei  
öglige

4 ülü öggümüi. qara ügei sayiqan sedkil-iyer ülü sanamui.

(Аяа бас хариугүй өглөг үл өгнө. Харгүй сайхан сэтгэлээр үл санана).

### 2.3. Нэмэлт баймж чанар.

Өгүүлэмжийн агуулга ба үнэлэмжийн харьцаанд тулгуурлах нэмэлт баймж чанар нь тухайн өгүүлэмжийн агуулгад хандах өгүүлэгчийн хувийн хандлага, субъектив үнэлэмж, таашаал зэргийг нээн илрүүлж нэмэн тодорхойлдог бөгөөд өгүүлэгчийн хэлэхүйн сонголттой холбогдон тухайн нөхцөл байдал, харилцааны онцлогоос болж янз бүрийн хувилбар, эгэл утгаар хэлбэрждэг байна.

Энэхүү баймж чанарын хүрээнд холбогдох “хөөрхий”, “аяа” гэсэн баймж үг тус сургаалын зохиолд хэдэнтээ дурдагдсан байна.

“Хөөрхий” гэдэг үгийг монголын болон монголч эрдэмтэн, судлаачид аялга үг, уулга үг, баймж үг, баймж (аялга) үг гэх мэтээр нэрлэн тодорхойлдог.

Энэ гар бичмэлд хөөрхий (köürikei) гэдэг баймж үг “... amitan бүгүде köürikei (7v, м 6), “... amitan бүгүде köürikei (7v, м 8), “... ičigür ügei amitan бүгүде köürikei” (8r, м 1-2), “... tuyilbar ügei sedkilten

Д.Равжаагийн “Цаасан шувуу” зохиолын нэгэн гар бичмэлд хийсэн баймж утгын задлал

köürikei” (8r, м 4), “... amitan бүгүде dangči köürükii” (8r, м 8) хэмээн 5 удаа өгүүлбэрийн эцэст тохиолдсон байлаа. Жишээлбэл:

[7v]

3 (...) tobčilbasu sangsar-un gingdan-dur üile-ber küligdeǰü. mungqaγ-un

4 qarangqui-yin dotur-a tačiyangγui-bar soǰtuǰu. uriñ-u mes-yi bariγad.

5 omuǰ-yiar tüligdeǰü atay-a-bar en[el]eng ǰobalang-yin ebderseyel-eyer emgenekü

6 amitan бүгүде köürikei.

(Товчилбол

Сансрын гянданд үйлээр хүлэгдэж

Мунхагийн харанхуйн дотор тачаангуйгаар согтож

Урины мэсийг бариад, омгоор түлэгдэж

Атаагаар энэлэн зовлонгийн эвдэршээлээр эмгэнэх

Амьтан бүгд хөөрхий).

Энэ таван жишээ нь “Монгол хэлний найруулгын төрлүүд дээр ажиглалт хийхэд, “хөөрхий” гэдэг баймж (аялга) үг нь үйл байдлыг зааж, үйл үгийн утга, үүрэгтэйгээр өгүүлэхүүн байрлал дээр хэрэглэгддэг өвөрмөц онцлог ажиглагдав” (Б.Пүрэв-Очир 2009:88) гэсэн судлаачийн дүгнэлтийг баталгаажуулсан тодорхой баримт болж байна.

#### **2.4. Субъектив баймж чанар.**

Баймжийн айн захын тогтолцооны мэдэхүүний талд холбогдох энэхүү баймж чанарын нэг томоохон төрөл зүйл болох захиран хүсэх баймж чанарын хоёр хэв шинж энэхүү сургаалын зохиолын гар бичмэлд бүртгэгдэв. Үүнд:

**Хоёрдугаар биеийн захиран хүсэх утга.**

Монгол хэлний хоёрдугаар биеэр төгсгөх 0 (тэг) нөхцөлөөр хэлбэржсэн өгүүлэмж энэ сургаалын зохиолд 94 удаа орсноос 57 өгүүлэмж нь “бүү + үйл үг + о нөхцөл” гэсэн загвараар, 1 өгүүлэмж нь “битгий + үйл үг + о нөхцөл” гэсэн загвартай бөгөөд үлдсэн 36 өгүүлэмж нь “үйл үг + о нөхцөл” гэсэн загвартай байна. Жишээлбэл:

[11r]

2 (.....) sayin-  
ača büü

3 sala. sadun-i büü eri. olan-i büü arilči. oġtu büü qarmala.

(Сайнаас бүү сал. Садныг бүү эр. Олон бүү арилж. Огт бүү харамла).

[13v]

1 (.....) urida-yin ki[g]sen kilingče-eče qour-a аууġsan metü qasir .

(Урьдын хийсэн хилэнцээс хор уусан мэт хашир).

Энэчлэн эл загварын гол үйл үгийн байранд *хориг тавь-, хүндэл-, баярлуул-, өргө-, зайл-, нөхөрлө-, дутаа-, номхотго-, ухуул-, баясга-, хэрэгс-, загна-, хүндэл-, өг-, зөвш-, гарга-, шүт-, боо-, хашир-, энхрийл-, зайл-, өргө-, нуу-, ундраа-, чиглэ-, зүтгэ-, барь-, хайрла-, алдариуул-, үйлд-, зайл-, үйлд-, тэвч-, шүт-, үз-, дар-* гэх мэтийн үйл үг тохиолдож байна.

Д.Равжаагийн “Цаасан шувуу” зохиолын нэгэн гар бичмэлд хийсэн баймж утгын задлал

### **Гуравдугаар биеийн захиран хүсэх утга.**

Монгол хэлний гуравдугаар биеэр төгсгөх - тугай<sup>2</sup> нөхцөл бүхий “үйл үг + тугай” загвараар хэлбэржсэн хэлбэр энэ гар бичмэлд ердөө ганц удаа дурдагдсан байлаа. Жишээлбэл:

[15v]

6 (.....) busud-un ergümčilel-yin ügen-dü kögeril ügei

7 nasuda öber-ün sedkel-i nam eyer daruču yabutuγai.

(Бусдын өргөмжлөлийн үгэнд хөөрөлгүй насад өөрийн сэтгэлийг намаар дарж явтугай).

Субъектив баймж чанарын хүрээнд тусгайлан онцолж дурдууштай нэг сонин утга бол хориглох баймж утга бөгөөд энэ утгыг илэрхийлэхэд “бүү”, “битгий” гэсэн хоёр угтан чимэх үг үлэмж идэвхтэй хэрэглэгддэг.

Бидний сонирхон үзэж байгаа сургаалын зохиолд энэ хоёр зүйл угтан чимэх үг хэрхэн хэлбэржсэнийг байцаан үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

- “бүү + үйл үг + о нөхцөл” гэсэн загвараар 57 өгүүлэмж байна. Жишээлбэл:

[11r]

8 (.....) qočurču nökür ügei büü sayu .

9 sabay-a ügei toγlayan büü toγla.

(Хоцорч нөхөргүй бүү суу. Саваагүй тоглоон бүү тогло).

[12r]

3 (.....) sanaγsan büri-yi büü iledge. tere ene gečü büü ilγ-a.

(Санасан бүрийг бүү илтгэ. Тэр энэ гэж бүү ялга).

Энэ мэтээр дээрх загварын гол үйл үгийн байранд бүү хард-, бүү нөхөц-, бүү хэл-, бүү үйлд-, бүү үүсгэ-, (гэм) бүү эр-, бүү сал-, (садныг) бүү эр-, бүү арилж-, бүү харамла-, бүү арвитга-, бүү сал-, бүү нөхөц-, бүү өмс-, бүү гайхуул-, бүү үүсгэ-, бүү гарга-, бүү урва-, бүү суу-, бүү тогло-, бүү хэл-, бүү зөвш-, бүү гарга-, бүү март-, бүү зөө-, бүү хэл-, бүү сэтгэ-, бүү залхайр-, бүү итгэ-, бүү урьт-, бүү өмөөр-, бүү шуна-, бүү загна-, бүү үүсгэ-, бүү алгас-, бүү дууриа-, бүү ярь-, бүү гомд-, бүү холд-, бүү март-, бүү учир-, бүү илтгэ-, бүү ялга-, бүү зарла-, бүү уурла-, бүү урва-, (арилжаа) бүү хий-, (өр) бүү хий-, (өглөг) бүү тасал-, (хулгай) бүү хий-, бүү загна-, бүү буц-, бүү март-, бүү болго-, (чиггүй) бүү суу-, (зангүй) бүү суу- гэх мэтийн үйл үг тохиолдсон байна.

- “битгий + үйл үг + о нөхцөл” гэсэн загвартай нэг өгүүлэмж байна.  
Жишээлбэл:

[12v]

7 (.....) qobči kümün-tei

8 kelelčebesü busud-yin gem-i sonusqu tula üge-i bidkii itege.

(Ховч хүнтэй хэлэлцвэл бусдын гэмийг сонсох тул үгийг битгий итгэ).

### **Товч дүгнэлт.**

- “Цаасан шувуу” зохиолын бидэнд хадгалагдаж байгаа эх нь 1992 оны эхээс олон талаараа ялгаа зөрүүтэй байгаа бөгөөд хэд хэдэн мөр, холбоо үг, үг зэргээр 1992 оны эхэд нэмэлт хийх боломжтой байна.

- Энэхүү гар бичмэлд монгол хэлний баймжийн айн төвийн болон захын тогтолцооны 8 үндсэн баймж чанарын 7 нь товч, дэлгэрэнгүй ямар нэгэн байдлаар хэлбэржсэн байна.

Д.Равжаагийн “Цаасан шувуу” зохиолын нэгэн гар бичмэлд хийсэн баймж утгын задлал

- Энэ гар бичмэлийн эхэд баймжийн айн төвийн болон захын тогтолцоонд хамаарах баймж утгын хэв шинж, утгын өнгө аяс илэрсэн байдал нь уг сургаалын зохиолын ерөнхий агуулга, үзэл санаа зэрэгтэй яв цав тохирсон, өөрөөр хэлбэл, логик-хэл зүйн талаасаа ямар нэгэн зөрчилгүй гэж үзэж болохоор байна.

- Үгүйсгэх баймж утга илэрхийлдэг “үл”, “эс” хэмээх утган чимэх үгийн “үл” нь хамгийн олон удаа тохиолдсон байна.

- Зайлшгүй баймж чанар илэрхийлдэг “хэрэгтэй”, “хэрэггүй” хэмээх хоёр баймж үг ерөнхийдөө ойролцоо тоогоор хэлбэржсэн нь энэхүү сургаалын зохиолын зайлшгүй ба зайлшгүй бус утгат агуулга үндсэндээ тэгш хуваарилагдсаныг харуулж байна.

- Хориглох баймж утга илэрхийлдэг “бүү”, “битгий” гэсэн хоёр утган чимэх үг бусад чимэх үгээ бодвол хамгийн их давтамжтай хэрэглэгдсэн нь энэхүү зохиол нь сургаалын зохиол болохыг давхар баталж байна.

### **Холбогдох ном зохиол**

Мөнх-Амгалан, Ю. Орчин цагийн монгол хэлний таамаглах баймж чанар. Хэл бичгийн ухааны докторын зэрэг горилсон зохиол. Уб., 1993. 171 тал.

Мөнх-Амгалан, Ю. Орчин цагийн монгол хэлний баймжийн ай. Уб., 1998. 370 тал.

Пүрэв-Очир, Б. Монгол хэлний “аяа”, “хөөрхий” хэмээх хоёр баймж үгийн урансайхны эхийн найруулга дахь хэрэглээ, утга, үүрэг. - Б.Пүрэв-Очир. Үг, өгүүлбэрийн амьдрал араншин, эрчим эхерги, соёл хэрэглээ. 7. Уб., 2009. 72-96 дахь тал.

Равжаа, Д. Яруу найргийн цоморлиг. Эмхэтгэж хэвлэлд бэлтгэсэн доц. Д.Цагаан. Редактор доктор Д.Ёндон. Соёмбо хэвлэлийн газар. Уб., 1992.

**Товчилсон үг, тусгай тэмдгийн жагсаалт**

**абв** гар бичмэл эхэд тухайн зүйлийг дарсан нь

**м** мөр

**г** recto буюу хуудасны нүүр тал

**v** verso буюу хуудасны ар тал

**☞** эх бичвэрийн эхлэлийн тэмдэг буюу бярга

**❖** эх бичвэрийн төгсгөлийн тэмдэг буюу талст маягаар байрласан дөрвөн цэг


**Х** анх бичээч юм уу тэр үеийн ариутган шүүгч оруулбар хийсэн нь

Д.Равжаагийн “Цаасан шувуу” зохиолын нэгэн гар бичмэлд хийсэн баймж  
утгын задлал

**Зураг № 1. Д.Равжаагийн “Цаасан шувуу” зохиолын нэгэн гар бичмэлийн  
гадар хавтас. 1г.**




Зураг № 2. Д.Равжаагийн “Цаасан шувуу” зохиолын нэгэн гар бичмэлийн эхлэл хэсэг. 2г.



Д.Равжаагийн “Цаасан шувуу” зохиолын нэгэн гар бичмэлд хийсэн баймж  
утгын задлал

Зураг № 3. Д.Равжаагийн “Цаасан шувуу” зохиолын нэгэн гар бичмэлийн  
төгсгөл хэсэг. 17v.



## ABSTRACT

# An analysis of Early Modern Mongolian mood and modality as expressed in a manuscript of D. Rawjaa's "The Kite"

Munkh-Amgalan YUMJIR  
Orkhon University, MONGOLIA

This paper presents a brief philological and linguistic study of a handwritten Literary Mongolian manuscript of the 19th century Gobi Mongolian Nyingma Buddhist monk and prolific polymath D. Rabjaa's (Dulduitiin (Danzan) Rawjaa) famous didactic work "The Kite" (in modern Mongolian: *Tsaasan Shuwuu*) which is in the author's possession, including a textual comparison with D. Tsagaan's 1992 modern Cyrillic edition and an attempt toward a comprehensive study of early modern Mongolian mood and modality as expressed in this text. The paper first addresses the physical condition of the manuscript and its details of its transmission, including the dimensions and quality of the paper and other physical characteristics of the manuscript as well as its significance in comparison with other known manuscripts of this important early modern Mongolian text. The author then presents glossed philological transcriptions of specific passages of the manuscript exhibiting expressions of grammatical mood and modality, juxtaposed and compared with the modern edition of D. Tsagaan, highlighting key differences between the manuscript and the modern edition. The author identifies instances of eight basic modal categories in the manuscript, analyzing their basic and peripheral semantic typology within the context of the

Д.Равжаагийн “Цаасан шувуу” зохиолын нэгэн гар бичмэлд хийсэн баймж утгын задлал

didactic content of this literary work, thereby offering contributions to increasing our understanding of the expression of mood and modality in early modern Mongolian.